



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/595

Улаанбаатар хот

「Баянгол дүүргийн 161 дүгээр цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад
шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 639,100.00 (зургаан зуун гучин есөн мянган нэг зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу тухайн байгууллагын балансад шилжүүлэн данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн 161 дүгээр цэцэрлэг (Г.Олонцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол 34 дүгээр цэцэрлэг (Ж.Оюунцэцэг)-т зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 455 дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 161 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Үзүүлэлт	Ашиглал-тад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагд-сан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Гурил зуурагч		2012.12.31	ш	1	639,100.00	639,100.00	410,088.95	229,011.05	Баянгол дүүргийн 34 дүгээр цэцэрлэг
	Нийт шилжүүлэх машин, тоног төхөөрөмжийн дүн						639,100.00	410,088.95	229,011.05	